



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, II хороо, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 70112333, Факс: (976-11) 31-23-15
E-mail: info@mrt.gov.mn, <http://www.mrt.gov.mn>

2016.06.25 № 38-04-058/080

**Стандартын шаардлага
хангасан тухай**

Зам тээврийн яамтай байгуулсан гэрээнд тусгагдсны дагуу “стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх” ажлын хүрээнд Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга П.Билгүүний баталсан 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 38-07-003/014 бүхий дугаар удирдамжийн дагуу танай компанийн захирал Х.Доржсүрэнг байлцуулан тээвэрлэгч жолооч, тээврийн хэрэгслүүдэд Авто тээврийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын шаардлага хэрхэн хангасан байдалд хяналт шалгалт хийлээ.

Тодорхойлох нь:

Шалгалтад тус байгууллагын Солонгос улсад үйлдвэрлэсэн KIA GRANBIRD, DAEWOO маркийн том оврын нийт 16 автобус болон 20 тээвэрлэгч жолооч хамрагдлаа.

1. “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS4598:2011 улсын стандартын шаардлагын 8.1.1-д “Улс хоорондын, хот хоорондын, хот орчмын харилцаанд ажиллах автобус нь 1-ээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар олон суудал, гар тээшний тавиураар тоноглогдсон, тээш хадгалах хонгил байна” гэсэн заалтыг;

2. Тээврийн хэрэгсэл дотор замналын нэр, эцсийн ба дундын зогсоолуудын нэр, ачааны жин, овор хэмжээний талаарх санамжийг нийтэд мэдэгдэхээр бичиж байрлуулсан байгаа нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011 улсын стандартын 5.6, 5.7 дахь заалтуудыг;

3. Нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл дотор замналын зураг болон тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг, заалт, бусад санамжууд/суудлын бүс, үнэ хөлс, цагийн хуваарь/-ыг зохих стандартын дагуу бичиж байрлуулсан нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011 улсын стандартын 5.9 дэх заалтыг;

4. Жолооч нарыг эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт жил бүр хамруулж, ажлын хувцасаар хангаж, нэрийн хуудсыг тээврийн хэрэгслийн дотор байрлуулсан нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011 улсын стандартын 6.7, 6.8 дахь заалтуудыг тус тус хангасан байна.

Дүгнэлт

1. Танай компанийн тээврийн хэрэгслүүд, тээвэрлэгч жолооч нар нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5012:2011 улсын стандартын 7.1, 8.2.1 дэх заалтыг бүрэн хангасан;

2. Цаашид тээврийн хэрэгслийн ялгах туузыг болон холбогдох санамж, бичгүүдийг тухай бүрт шинэчлэх, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS5012:2011 улсын стандартын 7.1-д заасны дагуу зорчигчдын ая тухтай, аюул осолгүй зорчих, аялах нөхцөл бүрдсэн, техникийн хувьд бүрэн бүтэн “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS4598:2011 улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэх шаардлагатай гэж дүгнэлээ.

АВТО ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Хүлээн авсан:
“АЯНЫ ЗАМ АЛТАЙ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Л.БАТГЭРЭЛ



Х.ДОРЖСҮРЭН